



ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ



ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2022 ОН

Ж.Даваалхам
Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
АУ-ны доктор

Нэг. Зохион байгуулалтын талаар

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын 2021 оны 9/30-ны өдрийн А/203 тоот тушаал “Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай”, 10/22-ны өдрийн А/222 тоот “Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм, мэргэжлийн цол олгох журам шинэчлэн батлах тухай” тушаалыг тус тус мөрдөж ажилласан. Эрдмийн зөвлөл нь **тэргүүлэгч гишүүд 15, өргөтгөсөн хурлын гишүүд 37, нийт 52 эрдэмтдээс** бүрдэж үйл ажиллагаа явууллаа.



Бүрэлдэхүүний хувьд, Академич, АШУ-ы доктор, Профессор, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, Хөдөлмөрийн баатар 1, Академич, АШУ-ы доктор, Профессор, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан 1, Академич, БШУ-ы доктор, Профессор, Төрийн соёрхолт 1, Академич, БШУ-ы доктор, Профессор 1, АШУ-ы доктор, Профессор 1, АУ-ы доктор, Профессор, Монгол улсын гавьяат багш 1, АУ-ы доктор, Профессор 7, АУ-ы доктор, Дэд профессор 10, АУ-ы доктор, Клиникийн профессор 6, АУ-ы доктор 17, Клиникийн профессор, Хүний гавьяат эмч, зөвлөх 1, БУ-ы доктор 2, Боловсрол судлалын доктор 2, Мал эмнэлгийн ухааны доктор 1

Хоёр. Эрдэм судлалын үйл ажиллагааны тайлан

2.1. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Нийт 10 удаагийн хурлыг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Хэлэлцсэн асуудлууд:

1. Судалгааны ажлын арга аргачлал – 15
2. Төсөлт, судалгааны ажлын явцын тайлан – 7
3. Төсөлт, судалгааны ажлын тайлан – 3
4. Төвийн хэмжээнд хэрэгжиж буй ОУ-ын томоохон судалгааны ажлын явц, тайлан – 6
5. Мэргэжлийн цол олгох – 1

